МЭДЭЭ · 2026 оны 9-р сарын 15

ЭРҮҮ ШҮҮЛТ ТУЛГАХ ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛҮҮЛЛЭЭ



"Эрүү шүүлт тулгах" гэмт хэргийн гаралт, түүний шийдвэрлэлтийн талаарх тоон мэдээллийг иргэдийг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс болон төрийн албан хаагчийг тус гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор хүргэж байна.

Прокурорын байгууллага 2026 оны эхний 8 сарын байдлаар эрүү шүүлт тулгах гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан 9 хүнд холбогдох 5 хэрэгт хяналт тавьж, 7 хүнд холбогдох 3 хэрэгт Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Эрүү шүүлт тулгах)-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлсэн.

Шүүхэд шилжүүлсэн хэргээс нийт 2 хэргийг анхан шатны шүүхээр шийдвэрлүүлээд байна.

Энэ төрлийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэрэг өмнөх оноос 1 хэрэг буюу 16.6%-иар, шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэрэг өмнөх оноос 4 хэрэг буюу 66.6%-иар тус тус буурсан байна.

Иргэн танд

> Эрүүгийн хууль 21.12 дугаар зүйл. Эрүү шүүлт тулгах

> Төрийн албан хаагч тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/391